

Биеэ үнэлэгчид нь сургагчийн хувьд

Биеэ үнэлэгчид нь Австралийн насанд хүрэгчид, эсрэг хүйстэн ба ижил хүйстнүүдэд бэлгийн боловсролыг хамгийн үр дүнтэй олгодог гэж Серена Мавулиза ба Кенн Робинзон нарын тайланд дурьдагдсан байна¹.

Дэлхий дээрх биеэ үнэлэгчид нь БЗДХ болон ХДХВ-ийн ямар ч шинжилгээнд хамрагдаагүй хүмүүстэй харьцдаг.

Үйлчлүүлэгчид нь биеэ үнэлэгчдийг бэлгийн ажилд дадлагатай гэж үзэн, эмчид ханддаггүй мөртлөө тэднээс асуулт асуудаг бөгөөд тэднийг ХДХВ/ДОХ-той холбоотой мэдлэг, мэдээлэл олгох мэргэжлийн эх сурвалж гэж үздэг.

Австралийн биеэ үнэлэгчид нь бэлгийн эрүүл мэндийн өндөр түвшинг харуулдагаараа бахархадаг. Австрали дахь ХДХВ-ийн халдвар 20-иод жилийн турш биеэ үнэлэгч ба үйлчлүүлэгчийн хооронд халдварын тохиолдол илрээгүй².

түүнчлэн БЗДХ авсан нийт хүмүүс дотроос биеэ үнэлэгчид хамгийн бага хувийг эзэлдэг.

Австралийн биеэ үнэлэгчдийн бэлгийн эрүүл мэндийн тухай мэдлэг сайн бөгөөд үүнтэй холбогдуулан хуулийг сайжруулах хэрэгтэй. Ихэнх газруудад биеэ үнэлэх ажлыг гэмт хэрэг гэж үздэг. Биеэ үнэлэгчид нь өндөр түвшинд хамгаалттай бэлгийн харьцаанд байдаг.

Эмэгтэй биеэ үнэлэгчид нь /биеэ үнэлэгчдийн байгууллагын хамгийн том бөгөөд судлагдсан бүлэг/ бэлгэвчийг амандаа, шулуун гэдсэндээ, бэлэг эрхтэндээ углаж хэрэглэдэг. Австралийн биеэ үнэлэгчдийн бэлгэвчийг өргөнөөр хэрэглэж байгаа шалтгаан нь халдвараас сэргийлэх бөгөөд биеэ үнэлэгч ба үйлчлүүлэгчийн хоорондын үл ойлголцох байдлаас хамгаалдаг. Австрали дахь эмэгтэй биеэ үнэлэгчид нь ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх, түүнчлэн хамгаалалттай бэлгийн харьцааг дэмжих бөгөөд үйлчлүүлэгчдийн бэлгэвчийг эсэргүүцэхийг багасгах явдал юм.

Эрэгтэй биеэ үнэлэгчид нь ХДХВ/ДОХ-ын талаар буруу ойлголттой үйлчлүүлэгчдэд мэдлэг мэдээлэл олгоно.

Тухайлбал: Эрэгтэй биеэ үнэлэгчээр үйлчлүүлж буй эрэгтэй үйлчлүүлэгчид “би гэрлэсэн тиймээс би цэвэр. Хоёулаа бэлгэвч хэрэглэх шаардлагагүй” эсвэл “би ижил хүйстэн биш учраас надад ХДХВ-ийн халдвар байхгүй” гэх мэтээр ятгахыг оролддог. Тиймээс бэлгэвчний хэрэглээ болон түүний мэдлэгийг үйлчлүүлэгчиддээ өгөх нь зөвхөн ДОХ-ын эрсдэлээс хамгаалах бус бусад БЗХӨ-нээс сэргийлэх боломжтой.

Биеэ үнэлэх ур чадвар

Биеэ үнэлэгч нь үйлчлүүлэгчдтэйгээ хамгаалттай бэлгийн харьцаанд орохын тулд олон төрлийн чадварыг эзэмшдэг. Үүний сайн жишээ бол бэлгэвчийг амандаа хийх юм. Энэхүү бэлгэвч хийх арга барил нь үйлчлүүлэгчийн дүр хүсэл буурахаас сэргийлэх бөгөөд хамгаалттай бэлгийн ажилд хэрэгтэй. Бэлгийн ажил нь бэлгэвчээс болж зогсохгүй байхын тулд үүнийг ашиглана. Бэлгийн дүр хүслийг бууруулахгүй байхын тулд зарим биеэ үнэлэгчид нь бэлгийн ажил эхлэхээс өмнө бэлгэвчийг хажуудаа бэлдэж тавьдаг.

Биеэ үнэлэгчдийн үйлчлүүлэгчдэдээ өгөх бэлэг нь бэлгийн амьдралыг хөгжүүлэх явдал юм. Бидний зан үйлийн хувьд энгийн бэлгийн харьцаа нь эр бэлэг эрхтэн эм эрхтэнд нэвтрэхийг хэлдэг. Эсрэг хүйстэнтэй харьцдаг эрэгтэй нь үүнийг ухаардаг бөгөөд бэлгийн бусад сонирхолтой ажиллагааны тухай мартдаг.

Эмэгтэй биеэ үнэлэгчдийн хувьд, тэд нар албан бус үе тэнгийн сургалт, ажлын байранд, биеэ үнэлэх газрын хамтран ажиллагсад буюу биеэ үнэлэгчдийн байгууллагаар дамжуулан үе тэнгийн сургалтаар дамжуулан сурдаг бөгөөд тэд нар дүр хүслийн мэдрэмжийн олон төрлийн мэдрэмжийг хөгжүүлдэг. Жишээ нь, бүтэн биеийн иллэг, /биеэрээ шүргэлцэх иллэг/, хөхөнд хийх /биеэ үнэлэх байгууллагад Испани бэлгийн харьцаа гэж нэрлэдэг/, үйлчлүүлэгчийн хөхний товчоор тоглох. Эдгээр үйлдлүүд нь эмэгтэй эрэгтэй хүний бэлгийн харьцааны хугацааг, бэлгэвч хэрэглэхэд гардаг асуудлуудыг болон хийх ажлыг багасгадаг.

Харамсалтай нь, бүх нийтийн бэлгийн зан үйлийн тухай эсрэг мэдээний талаар дархлаажилт биеэ үнэлэгчдэд байхгүй. Бэлгийн харьцаанд ордог бүх эмэгтэйчүүд болон эмэгтэй биеэ үнэлэгчид бүгд шившигт ордог. Түүнчлэн, биеэ үнэлэгчид нь бэлгийн харьцааны тухай шившигтэй санагддаг ч гэсэн тэд бэлгийн харьцааны тухай нээлттэй бөгөөд итгэлтэйгээр ярьдаг. Тэд нар бэлгийн ажлын талаар өөртөө итгэлтэй ярьдаг. Мэргэжлийн байгууллага нь бэлгийн ажлын тухай ярих нөхцөл бололцоогоор хангаж өгдөг. Бид зөвхөн бэлгийн харьцааны талаар ярих биш харин бэлгийн харьцааны үйл ажиллагаа, түүний гайхамшиг болон бэлгийн хүсэл буюу бэлгийн хязгаарлалтын тухай ярина. Биеэ үнэлэгчид нь бэлгийн ажил ба ХДХВ-ын боловсролын талаар бид итгэлтэйгээр, өөрсдийн мэдлэгийн хүрээнд ярих бөгөөд энэ ХДХВ-ын боловсрол нь бага үүрэг биш юм. Энэхүү нээлттэй байдал нь бэлгийн харьцааны судалгааны талаар шүүмжлэх бус харин үйлчлүүлэгчидэд эрсдэл багатай, эрүүл, тааламж өгөхүйц байх бололцоог нэмэгдүүлж байдаг.

Reprinted from Volume. 3 No. 1, Sept – Nov 2003, of *HIV Australia*, published by the Australian Federation of AIDS Organisations. Link to original article:

http://www.afao.org.au/view_articles.asp?pxa=ve&pxs=95&id=335

1. Биеэ үнэлэгчдийн үйлчлүүлэгчидийн дийлэнх нь эрэгтэйчүүд ба дээрхи өгүүлэлд эрэгтэй үйлчлүүлэгчдийг онцолж авсан
2. Harcourt, C, 1994, "Prostitution and Public Health in the Era of AIDS." In *Sex Work and Sex Workers in Australia*, edited by R. Perkins, G. Prestage, R. Sharp and F. Lovejoy, University of NSW Press, Sydney: 218-219.